



**ҮАГ**

**Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт, их засварын зардлын гүйцэтгэл, үр дүн**

**Хөрөнгө оруулалтын арга хэмжээний хяналтыг сайжруулж, үр өгөөжийг тооцох шаардлагатай байна.**

**УИХ-ын ЭЗБХорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**

Улаанбаатар 2006 оны 6 дугаар сар

---

# Агуулга

---

<b>Тайланг бэлтгэсэн:</b>  <b>ҮАГ-ын нэгдүгээр газар</b>  <i>Тэргүүлэх аудитор</i> <i>Д.Ганбилэг</i> <i>Аудитын менежер</i> <i>Ж Батсайхан</i> <i>Ахлах аудитор Л.Одгэрэл</i> <i>Бусад аудитор, шинжээчид</i>  <b>2006 оны 6 дугаар сар</b>  <b>Уг тайланг ҮАГ-ын</b> <b>вэб сайт-аас үзнэ үү:</b>  <b><u><a href="http://www.mnao.pmis.gov.mn">www.mnao.pmis.gov.mn</a></u></b>  <i>Аудитын тайлан, дүгнэлттэй</i> <i>холбоотой асуудлаар нэмж</i> <i>тодруулах, асууж лавлах зүйл</i> <i>байвал 261885 дугаарын утас,</i> <i>323266 дугаарын</i> <i>факсаар харилцана уу.</i>  <b>ХАЯГ:</b> <i>Үндэсний аудитын газар</i> <i>Засгийн газрын 4 дүгээр байр,</i> <i>Бага тойруу-6, Улаанбаатар-46</i> <i>Монгол Улс</i>	<b>Товчилсон үгсийн жагсаалт</b>	3	
	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b>	4	
	<b>Зөвлөмжийн хураангуй</b>	5	
	<b>Бүлэг 1</b>		
	<b>Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.</b>	6	
	<ul style="list-style-type: none"><li>Хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээг санхүүжүүлээгүй байна</li></ul>	6	
	<ul style="list-style-type: none"><li>Хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна</li></ul>	9	

---



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЗХСТ	Авто замын хяналт судалгааны төв
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
БОЯ	Байгаль, орчны яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
ГХАЭС	Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн сайд
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТАЖЯ	Зам тээвэр, аялал жуулчлалын яам
НББ	Нягтлан бодох бүртгэл
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
УБХТН	Улсын батлан хамгаалахад туслах нийгэмлэг
УГЕГ	Улсын Гаалийн ерөнхий газар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
УИХ	Улсын Их Хурал
СЭЗС	Санхүү, эдийн засгийн сайд
СЯ	Сангийн яам
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТӨУҮГ	Төрийн өмчийн улсын үйлдвэрийн газар
ТЭХЯ	Түлш, эрчим хүчний яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт, их засварын зардлын гүйцэтгэл, үр дүнд аудит хийв.

Энэхүү аудитын зорилт нь Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт, их засварын зардлын гүйцэтгэл, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган, зөрчил дутагдал илэрвэл тэдгээрийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж боловсруулахад чиглэгдлээ.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт, их засварын зардлыг хэрхэн төлөвлөж, хуваарилсан талаар судалгаа, тодруулга авах,
- Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт, их засварын зардлын гүйцэтгэл, түүнийг тайлагнасан байдлыг холбогдох / ҮХЯ, ХХААЯ, БХЯ, ЗТАЖЯ, НХХЯ, Хэнтий, Дундговь, Хөвсгөл аймгийн ХХҮХ, ҮТЕГ / байгууллагад түүвэрчлэн шалгах,
- Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт, их засварын зардалд батлагдсан хөрөнгийг гүйцэтгэлтэй нь харьцуулан дүн шинжилгээ хийх,
- Холбогдох байгууллага, хүмүүсээс тайлбар, нотолгоо авах, ярилцлага хийх, мөрдөгдөж буй журам зааврын талаар санал асуулга авах,

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## Бүлэг 1

### Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна




#### ***А. Хөрөнгө оруулалтын бус арга хэмжээг санхүүжүүлсэн байна.***

Монгол Улсын 2005 оны төсвийн тухай хуулиар 2005 оны төсвийн жилд дотоод эх үүсвэрээс хийх хөрөнгө оруулалтын хэмжээг 55952,6 сая төгрөгөөр тогтоосон байна.

Энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2005 оны 21 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгөөр 2005 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг төсөл, арга хэмжээ тус бүрээр баталжээ.

Дээрх шийдвэрийн дагуу 2005 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид 55952,6 сая төгрөгөөр зарцуулахаас гүйцэтгэлээр 54814,6 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийн 113,8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт дараахь бүтэцтэй байна. Үүнд:



Засгийн газрын 2005 оны 21 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна их засварт 4007,4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, төлөвлөсөн хэмжээнээс 476,2 сая төгрөгөөр илүү буюу 4483,6 сая төгрөг зарцуулсан байна.

Улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалтын бүтцийг авч үзвэл, 36,9 хувь нь авто замд, 26,1 хувь нь түлш эрчим хүчинд, 19,2 хувь нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд, 4,9 хувь нь хил хамгаалах, батлан хамгаалах, хууль хяналтын байгууллагуудад, 1,2 хувь нь хөдөө аж ахуйд, 1,7 хувь нь хот байгуулалт, нийтийн аж ахуйд, үлдэх 10 хувь нь төсвийн байгууллагуудын хөрөнгө оруулалтад зориулагдсан байна.

Дээрх хөрөнгийг СЭЗС-ын 2001 оны 174 дүгээр тушаалаар батлагдсан “Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын /цаашид “Журам” гэх/ дагуу СЯ эрх нээж санхүүжүүлсэн байна. Харин 661,7 сая төгрөгийг /Хавсралт / энэхүү журмын 3.2-т заасан баримт, материал бүрдээгүй учраас эрх нээж, санхүүжүүлэлгүй төвлөрсөн дансанд үлдээж, энэ хэмжээгээр хөрөнгө оруулалтын дүн багассан байна.

Журамд зааснаар Сангийн яам дараахь баримт, материалыг үндэслэн хөрөнгө оруулалтын арга хэмжээг санхүүжүүлэх эрх нээх ёстой. Үүнд:

1. Батлагдсан зураг, төсөв
2. Тендерийн хорооны тогтоол буюу зөвлөмж
3. Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажил, үүрэг гүйцэтгэх гэрээ
4. Барилга угсралт, засварын ажил гүйцэтгэх график
5. Санхүүжилтийн сар, улирлын хуваарь
6. Эргэж төлөгдөх нөхцөлөөр олгох зээлийн гэрээ

7. Захиалагчаар баталгаажуулсан барилга байгууламжийн болон засварын ажлын гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авсан акт
8. Эрх бүхий байгууллагын батлан гаргасан шийдвэр, барилга байгууламж, засварын ажлын норм, нормативууд

ЗТАЖЯ-ны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрх нээж санхүүжүүлсэн байдалд аудит хийхэд 2005 оны 12 дугаар сарын 28-нд ирүүлсэн 2522,6 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлэх хүсэлтийг СЯ хянан өмнө нь олгосон санхүүжилтийг хасч 1630,0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн нь журмын дагуу хийгджээ.

Харин Орхон аймгийн гэр хорооллын дундах 3,5 км замын ажлыг 2005 оны 10 дугаар сарын 18-нд 120,0 сая төгрөгөөр санхүүжүүлжээ. Гэтэл 2005 оны 12 дугаар сарын 29-нд гүйцэтгэл нь 59,1 сая төгрөг гарсныг / өмнөх санхүүжилтийг суутган тооцолгүй/ давхардуулан санхүүжүүлсэн байна. Энэ нь “Замын тухай” хуулийн 18.4-д “ Улсын авто замын санг олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, хамгаалах, тохижуулах, замын үйлдвэрлэлийн баазыг хөгжүүлэх, мэргэжлийн хяналт тавихтай холбогдон гарах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” гэж заасныг зөрчжээ. Өөрөөр хэлбэл, орон нутгийн авто замын ажилд улсын төсвөөс санхүүжилт олгосон байна. Иймд аудитаар 120,0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Зарим яам Засгийн газрын 2005 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын төсвийн хөрөнгөөр 2005 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад / нийт хөрөнгийн дүнд өөрчлөлт оруулаагүй/ уг тогтоолын 3 дугаар заалтыг үндэслэн тайлант оны эцэст дараахь өөрчлөлт хийжээ.

№	Өөрчлөлт хийгдсэн салбар	Сангийн сайдтай хамтарсан тушаал	Хөрөнгийн хэмжээ / сая төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	
				хасагдсан	нэмэгдсэн
1	Эрүүл мэндийн яам	19/XII 349/315	139.3	12	7
2	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам	3/X 262/307 14/X 274/322 19/XII 350/409	274.1	30	51
3	Зам тээвэр, аялал жуулчлалын яам	26/XII 367/205 12/XII 336/195	5118.5	27	31
4	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	7/VI 148/61 16/XII 344/127	110.0	2	5
5	Байгаль орчны яам	142/149	650.0	1	1
6	ҮТЕГ	28/XII 376	400.0	1	2
7	УГЕГ	8/XII 332	242.5		
8	Аймгийн шүүх	331	270.0	3	3
9	ҮХЯ	ЗГ-ын 103	472,0	6	1

Сангийн сайдын 2005 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 4-9а /412б дугаар албан бичгээр санхүүжилтийн материалыг 12 дугаар сарын 15-ны дотор авч, санхүүжилтийг 12 дугаар сарын 25-наас хойш хийхгүй байхаар шийдвэрлэсэн боловч хэрэгжээгүй байна.



Тухайлбал, ЗТАЖЯ 2005 оны 12 дугаар сарын 28-ны өдөр гүйцэтгэлээ ирүүлж Сангийн яам 12 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд 7225,8 сая төгрөгийн санхүүжилт хийсэн байна. ЗТАЖЯ 3734,8 сая төгрөгийн зохицуулалт хийсний 58 хувийг 12 дугаар сарын 29-ний өдөр, үлдэх хэсгийг 2006 онд санхүүжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ийнхүү зохицуулалт хийсэн нь төлөвлөлт бодитой бус байгааг харуулахаас гадна зохицуулалтыг оны эцэст хийснээс он дамжин санхүүжигдэх, хөрөнгө оруулалтын дансанд оны эцэст их хэмжээний үлдэгдэлтэй гарах нөхцөлийг бүрдүүлж байна.

### **Б. Хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.**

Журмын 3.18-д захиалагч хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, санхүүжилтийн тайланг улирал бүр гаргаж Сангийн яаманд ирүүлж байхаар заасан боловч тайланд ямар үзүүлэлтүүдийг тусгах талаар нэгдсэн маягт загвар, хөрөнгө оруулалтын зардлын үр ашиг, үр өгөөжийг тооцох аргачлал тодорхой тусгаагүй байна.

Дээрх байдлаас шалтгаалан яамд, өөр өөр үзүүлэлтээр СЯ-наас авсан санхүүжилтээрээ хөрөнгө оруулалтын тайлан гаргаж байна. Гэтэл СЯ-наас авсан санхүүжилтийг тогтоосон хугацаанд гүйцэтгэгчдэд өгөөгүй, он дамжуулсан байдал нь яамдын тайлангаас харагдахгүй байна.

Яамдын хөрөнгө оруулалтын тайланг СЯ нэгтгэн Төрийн сангийн газраас гаргасан мөнгөн суурьт хөрөнгө оруулалтын тайлантай тулгахгүй, зөвхөн СЯ-ны Төрийн сангийн газар, Салбарын бодлого зохицуулалтын газар хоорондын эрх нээсэн, санхүүжүүлсэн дүнтэй тулган мөнгөн суурьт хөрөнгө оруулалтын тайлан гаргаж байна.

Журам өнөөдрийн нөхцөлд тохирч байгаа эсэх талаар Сангийн яамны ажилтнууд болон захиалагчдын дунд санал асуулга явуулахад оролцогчдын 60 гаруй хувь нь уг журмыг шинэчлэх шаардлагатай гэж хариулжээ.

Сангийн яамнаас хийсэн санхүүжилтийг захиалагч хүлээн авсан боловч гүйцэтгэгчид өгөөгүй байсан тохиолдол гарчээ. БСШУЯ СЯ-аас авсан санхүүжилтийг гүйцэтгэгчдэд хугацаанд нь олгоогүй, санхүүжилтийн дүнг бууруулан дутуу санхүүжүүлсэн зэрэг зөрчил Сангийн яамны шалгалтаар илэрч байжээ.

Тухайлбал, 9 удаагийн санхүүжилтийг 6 хоног, 10 удаагийн санхүүжилтийг 14 хоног, 1 удаагийн санхүүжилтийг 2 хувааж 6-11 хоногоор саатуулсан байна. 2005 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 9 хоногоор саатаж байгаа 299,6 сая, 58 хоногоор саатаж байгаа 20,3 сая, гүйцэтгэгчид өгөөгүй авч үлдсэн 10,7 сая төгрөг, нийт 330,6 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчдэд өгөөгүй байжээ.

Эрдэнэсант-Лүн чиглэлийн замын шинэчлэлтэд 13,3 сая, Хархорин-Хөшөө цайдмын хатуу хучилттай замд 25,8 сая, Эрдэнэсант-Арвайхээр чиглэлийн замд 7,2 сая, Дэлхийн банкны Тээвэр хяналтын төвийн дотоод эх үүсвэрт 4,0 сая, Дархан-Эрдэнэтийн зам засварт 8,9 сая, Баруун урт-Өндөрхааны зам засварт 19,4 сая, нийт 78,6 сая төгрөгийг олгосон боловч ЗТАЖЯ гүйцэтгэгчдэд олгоогүй байна.

Сангийн яам зөвхөн захиалагчийн өгсөн санхүүжилтийн баримтыг шалгах байдлаар хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж байна. Сангийн яамны Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтнүүд 2005 онд 11 объектод очиж гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн байна.

СЯ хөрөнгө оруулалтын санхүүжилтийг давхардуулан олгож, хариуцлага алдаж байжээ. Тухайлбал, СЯ-наас ЗТАЖЯ-нд Эрдэнэсант- Улаанбаатар чиглэлийн замын шинэчлэлтэд 70,0 сая, Хархорин Хужиртын зам хайгуулын ажилд 125,0 сая, Номгон хайрхан ХХК-д замын сүлжээний засвар арчлалтад 98,2 сая, нийт 293,2 сая төгрөгийн санхүүжилтийг давхардуулан олгож, 2006 оны 3 дугаар сарын 3-нд 381,0 сая төгрөгийг журмын дагуу гүйцэтгэгчид өгөөгүй гэдэг утгаар буцаан татсан байна.

Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчдад тавих хяналт хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, тайлант оны эцэст яам, агентлагуудын хөрөнгө оруулалтын дансны үлдэгдлийг шалгаж тухайн оны санхүүжилт бүрэн хэмжээгээр гүйцэтгэгчдээ очсон эсэх, барьцаа хөрөнгө авч үлдсэн эсэх талаар хяналт хийж чадахгүй байна. Тухайлбал,

- ЗТАЖЯ Чойр- Замын Үүд чиглэлийн замын зураг төсөлд санхүүжилтээс 10,9 сая, Өлгий- Цагааннуурын хатуу хучилттай замын санхүүжилтээс 23,2 сая төгрөгийг барьцаа болгон авч үлдсэн боловч гүйцэтгэгч нартай актаар баталгаажуулаагүй,
- Устын Уул- Дуутын давааны хатуу хучилттай замын санхүүжилтээс 264,4 сая төгрөгийг гүйцэтгэгчид дутуу санхүүжүүлсэн,
- 2005 оны гүйцэтгэлийн санхүүжилтээс барилгын захиалагчийн ажлын хяналтын зардал, төвлөрсөн шагналын сан, норм нормативын санд нийт 330,5 сая төгрөгийг суутган авч үлдэн 144,0 сая төгрөгийг АЗХСТ-д шилжүүлсэн гэж АЗХСТ- тэй актаар баталгаажуулжээ. Гэтэл ЗТАЖЯ-ны харилцах данснаас АЗХСТ-д захиалагчийн хяналтын зардалд 275,0 сая төгрөг, норм нормативын санд 8,9 сая төгрөг шилжүүлсэн байна.

**Зөвлөмж: Сангийн сайд н. Баяртсайханд**

- “Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх,
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалтад тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох,

## Бүлэг 2

**Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох нэгдсэн үзүүлэлт алга байна.**



### ***А. Гүйцэтгэгчийг зохих журмын дагуу сонгон шалгаруулаагүй байна.***

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, их засварын ажлын гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу тендер зарлаж, сонгон шалгаруулах журамтай.

Аудитад хамрагдсан зарим байгууллагад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг хуулийн дагуу явуулаагүйн гадна гэрээ байгуулалгүй ажил эхлүүлсэн дутагдал илэрлээ. Тухайлбал,

ҮХЯ-нд Улаандаваа, Дөргөн, Их Монгол уул, Дэлгэрцогт, Гурван овоот, Баавхайн хонхор, Модон, Нөмрөг зэрэг 9 газарт геологийн зураглал хийх нийт 485,0 сая төгрөгийн төслийн тендер шалгаруулах ажиллагааны талаар гомдол гарсан учраас хойшилсон байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмж тусгагдсан Алтанбулаг, Шарга-3 төсөлд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгөөс 96,0 сая төгрөг тухайн цаг хугацааны хувьд ашиглагдах боломжгүй болсон, Баруун, Төв, Дорнод, Өмнөд бүсийн Улсын геологийн 1:200000 масштабын зураг зохиох 4 ажлыг тендер зарлалгүй Геологийн мэдээллийн төв ТӨУҮГ-аар хийлгэхээр болсныг хуулийн зөрчсөн гэж үзэн гэрээ батлагдаагүй зэрэг шалтгаанаар ҮХЯ төлөвлөгөөт ажлаа 2005 онд багтаан хийж чадахгүйд хүрсэн байна.

ҮХЯ Уул уурхайн хүрээлэнтэй “Геологи уул, уурхайн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, уул уурхайн салбарын

хэтийн тогтвортой хөгжлийг хангах арга зам болон эрдэс баялгийн нөөцийн ангилал, уул уурхайн болон металлургийн төслүүдийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага, стандарт боловсруулах” төслийг 2005 онд 55.0 сая төгрөг, 2006 онд 40.0 сая төгрөг, нийт 95.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх, 2005 оны 6 дугаар сараас эхлэн 2006 оны 6 дугаар сард дуусгахаар хязгаарлагдмал тендер 2005 оны 6 дугаар сарын 3-нд шалгаруулж СЯ-ны холбогдох газраар хянуулалгүй гэрээ хийсэн байна.

ҮХЯ-ны конторын барилгын их засвар хийх 138.5 сая төгрөг, түүний өргөтгөл барих 67.4 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хороог 2005 оны 6 дугаар сарын 23-нд, үнэлгээний хороог 2005 оны 6 дугаар сарын 27-нд байгуулсан боловч уг ажилд хөрөнгө гаргах тухай тушаал 2005 оны 7 дугаар сарын 7-нд гарсан, тендер, үнэлгээний хорооны ажлын материал байхгүй, барилгын ажил гүйцэтгэх гэрээ батлагдаагүй, хийгдсэн барилгын их засвар, өргөтгөлийн ажлыг зохих ёсоор хүлээн аваагүй байна. Мөн төсөв батлагдаагүй, тендерт шалгарсан тухай тендерийн хорооны зөвлөмж, төсөл хэрэгжүүлэх тухай шийдвэр гараагүй байхад ажлыг эхлүүлжээ.

ХХААЯ тендерийг оройтуулж зарласнаас худгийн засвар шинэчлэлийн зарим ажил өвөл хийгдэхэд хүрсэн байна.

Дундговь аймгийн ХХҮХ-ийн барилгын засварын ажилд тендер зарлалгүй тус хэлтсийн дарга, ня-бо нар өөрсдөө БНХАУ-ын Эрээн хотоос 8,9 сая төгрөгийн барилгын материал бэлтгэж, засварын ажлаа компани, хувь хүмүүстэй гэрээ хийж гүйцэтгүүлсэн байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг хэрэгжүүлж, улирлын онцлогтой ажилд тендер зарлах хугацааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

## **Б. Захиалагчийн хяналт хангалтгүй байна.**

Захиалагч нар гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд хяналт бүрэн тавьж, хөрөнгө оруулалтын журамд заасан санхүүжилтэд тавигдах шаардлагыг мөрдөж ажиллаагүй байна.

- БХЯ их засварын зардалд батлагдсан хөрөнгийг бүрэн санхүүжүүлсэн боловч үе шатаар санхүүжилт хийгээгүй байна. Шинээр баригдсан барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын шийдвэргүй тухайн цэргийн ангийн комисс дангаараа хүлээн авсан байна.
- ХХААЯ Дархан-Уул аймагт “Ус инженеринг” ХХК-ийн засварласан 10 худгийн санхүүжилтийн 30 хувийг гэрээ хийснээс ажлын 27 хоногийн дараа, үлдэх 70 хувийг орон нутгийн комисст хүлээлгэн өгч, гэрээ дүгнэснээс 20-24 хоногийн дараа, Дундговь аймагт засварласан 13 худгийн санхүүжилтийн 30 хувийг гэрээ хийснээс ажлын 20 хоногийн дараа, үлдэх 70 хувийн

санхүүжилтийг ажил хүлээлцэж, гэрээ дүгнэснээс ажлын 26 хоногийн дараа шилжүүлжээ.

“Ус инженеринг “ ХХК-ийн Дундговь аймгийн Говь-Угтаал суманд засварласан 4 худгийг ажлаа хийхээс өмнө орон нутгийн комисс (ажлыг 2005 оны 11 дүгээр сарын 10-18-ны өдрүүдэд хийсэн байхад орон нутгийн комисс урьдчилаад 2005 оны 11дүгээр сарын 8-13-ны өдрүүдэд хүлээн авсан) хүлээн авснаар акт бүрдүүлжээ.

- ҮХЯ “PAN alytical фирм” –тай 2005 оны 12 дугаар сарын 23-ны өдөр буюу төлбөр хийгдсэнээс хойш 63 хоногийн дотор тоног төхөөрөмж нийлүүлэхээр гэрээ байгуулж, 2006 оны 3 сарын 20-нд нийлүүлсэн байхад 2005 оны 12 дугаар сарын 27-нд нийт 399,1 сая төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг Геологийн төв лаборатори хүлээн авснаар хуурамч акт үйлджээ.

ҮХЯ “Геологи уул, уурхайн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, уул уурхайн салбарын хэтийн тогтвортой хөгжлийг хангах арга зам болон эрдэс баялгийн нөөцийн ангилал, уул уурхайн болон металлургийн төслүүдийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлага, стандарт боловсруулах” 95,0 сая төгрөгийн өртөгтэй төсөлд тендер зарлан Уул уурхайн хүрээлэнг шалгаруулж Сангийн ямаар хянуулан гэрээ байгуулан 28, 0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор 2005 онд 12 дугаар сарын 16-ны өдөр шийдвэрлэсэн байхад 2005 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 1/3364 дүгээр албан бичгээр энэ ажлыг санхүүжүүлэхийг Сангийн яамнаас хүсэж байжээ.

Геологийн судалгааны төв 2005 онд Эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлж хамгаалсан Цагаан уул-50, Дарцагт-50 төслүүдийн тайлангийн барьцаа болон урамшууллын санхүүжилтийг олгоогүй байхад ҮХЯ геологийн судалгааны ажилд хөрөнгө оруулалтаар олгосон хөрөнгийг хэмнэлтээр тооцсон байна.

- Чойр-Замын Үүд чиглэлийн хатуу хучилттай замын ажилд Сангийн сайд, ЗТАЖС-ын 2005 оны 367/205 дугаар тушаалаар зохицуулалт хийж 1200,0 сая төгрөг батлагдсан төсвөөс хассан байхад ЗТАЖЯ 2004 оны өглөгийн үлдэгдэл гэж МСРС ХХК-д 242,2 сая төгрөг шилжүүлсэн нь ондоо багтаан гүйцэтгэлээр санхүүжилт хийгээгүйг харуулж байна. ЗТАЖЯ нь АЗХСТ-тэй захиалагчийн хяналтын зардал, төвлөрсөн шагналын сан, норм нормативын санд санхүүжүүлэх тооцоог 7,5 сая төгрөг, санхүүжүүлсэн дүнг 139,9 сая төгрөгөөр зөрүүтэй хийжээ.
- ЭМЯ 2005 онд баригдаж эхлэх 130.0 сая төгрөгийн төсөвтэй Булган аймгийн Тэшиг сумын 15 ортой эмнэлгийн барилгын ажилд 2005 онд 40.0 сая төгрөгийн санхүүжилт олгоогүйгээс барилгын ажил 2006 оны 4 дүгээр сарын 15 гэхэд эхлээгүй байв.

ЭМЯ-наас 2005 онд Говьсүмбэр аймагт 30 ортой халдвартын эмнэлгийн барилга барихаар 135.0 сая төгрөгийн санхүүжилт авсан “Батс-Өргөө” ХХК аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварт 2,2 сая төгрөг төлөөгүй байсан тул төлүүлэхээр акт тогтоов.

Холбогдох мэдээ, тайланг буруу гаргаж ирүүлсэн, шаардлагатай баримт материалыг зохих ёсоор бүрдүүлж өгөөгүй, хуурамч баримт үйлдсэн этгээдэд зохих хуулийн дагуу хариуцлага тооцоогүй байна. Тухайлбал,

- Хөвсгөл „Дундговь, Хэнтий аймгуудийн ХХҮХ-ийн барилгын засварын ажлыг “ Сант-Өндөр” ХХК, “Суврага Эв” ХХК дуусган ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн гэж Улсын комиссын акт ирүүлсэн боловч тухайн компанийг сонгон шалгаруулсан эсэх нь тодорхой бус, барилгын засварын ажлын зураг төсөв, үндсэн баримт материал, гүйцэтгэлийн тайлан, бусад холбогдох материал байхгүй, баримт материалаа хүлээлгэж өгөөгүй, өөр барилгад / Хөвсгөл аймгийн ХХҮХ-ийн барилгын их засварт зориулан олгосон хөрөнгөөр УБХТН-ээс барилга худалдан авсан боловч хэдэн төгрөгөөр авсан нь тодорхойгүй, Хэнтий аймгийн ХХҮХ-ийн барилгын их засварт зориулж олгосон 12,0 сая төгрөгийг аймгийн Ахмадын үйлчилгээний төвийн барилга барихад ашигласан/ хөрөнгийг зарцуулсан, барилгын ажил дуусаагүй байхад хөрөнгийг бүрэн зарцуулсан гэж тайлан гаргаж ирүүлсэн байна.
- ҮХЯ-ны барилгын их засварын ажилд 16,7 сая төгрөг зарцуулж ажил хүлээн авсан актыг зохих ёсоор бүрдүүлээгүй байна.
- Хархорин-Хужирт чиглэлийн 38,2 км хайрган замын 1 дүгээр хэсгийн 21,4 км замын хиймэл байгууламжийн барилгын ажлыг “ Бөөн Улиас трейд” ХХК гүйцэтгэн улсын комисс хүлээн авч акт үйлдсэн боловч уг актыг үйлдсэн огноо, дугааргүй, ажлын чанар байдлын талаар тэмдэглэл алга байна.
- НХХЯ “Актив групп” ХХК-иар 2233,7 сая төгрөгийн өртөг бүхий засварын ажил гүйцэтгүүлсэн байна. Хүлээн авсан актанд ажлын чанар байдлын талаар ямар нэг тэмдэглэл алга байна.

ҮТЕГ, НХХЯ 2005 оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төсөвт төвлөрүүлээгүй байна. Үүнд:

- ҮТЕГ 2005 оны эцэст хөрөнгө оруулалтын дансанд байсан 177,4 сая төгрөгийн үлдэгдлээс 2006 оны эхний хоёр сард “MCS” ХХК-иас 29,1 сая төгрөгөөр компьютер, “Хурд авто” ХХК-иас 9,9 сая төгрөгөөр автомашин, “Түмэн ундрам” ХХК-иас 19,3 сая төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авсны гадна Сонгино Хайрхан дүүргийн Татварын хэлтсийн барилгын зураг төсвийн үнэнд 3,1 сая төгрөг төлж, үлдсэн 116,0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан шилжүүлсэн байна.
- НХХС-ын багцад төв, орон нутгийн байгууллагын хөрөнгө оруулалт, их засвар, хөтөлбөрийн арга хэмжээнд зориулан 150,0 сая төгрөгийн төсөв

батлагдсанаас 95.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 91,9 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлж 3,4 сая төгрөг зарцуулагдаагүй үлджээ.

СЯ 2005 оны эцэст 7225,8 сая төгрөгийн санхүүжилтийг ЗТАЖЯ-нд хийснээс тус яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын харилцах данс 2,9 тэрбум, замын сангийн харилцах данс 2,5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

НХХЯ, ХХААЯ, ҮХЯ гэрээгээ биелүүлээгүй дараахь гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцоогүй байна. Үүнд:

- Хэнтий, Хөвсгөл, Дундговь аймгийн ХХҮХ-ийн барилгын засварын гүйцэтгэгч “Сант-Өндөр”, “Суврага Эв” ХХК –ууд, Дундговь аймгийн ХХҮХ-ийн дарга, нягтлан бодогч нартай ямар нэг арга хэмжээ авч хариуцлага тооцоогүй, харин ч засварын ажил дууссан мэтээр Улсын комиссын акт үйлдэж, хаацайлсан байна.
- Дундговь аймагт худгийн засвар шинэчлэл хийх, шинээр худаг гаргах гүйцэтгэгчийг сонгох тендерийг / 6 дугаар сарын 22-ны өдөр тендер шалгаруулж/ оройтуулж, “Ус инженеринг” ХХК-тай 8 дугаар сарын 24-ний өдөр гэрээ хийж, гүйцэтгэгч гэрээний хугацаанд /9 дүгээр сарын 5-ны өдрөөс 10 дугаар сарын 15 -ны хооронд/ ажлаа эхлээгүй шалтгаанаар худаг засварлах, шинээр худаг гаргах хугацаа оны эцэс /11 дүгээр сарын 20-ны өдөр дуусгасан/ рүү шахагдаж, цаг уурын байдал хүйтэрсэн үед барилгын ажил хийгджээ.
- ҮХЯ “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн харуул хамгаалалтын барилга байгууламжийг барих 615,9 сая төгрөгийн ажлыг “Баярс констракшн” ХХК 2004 оны 8 дугаар сарын 8-ны өдөр эхэлж 2005 оны 2 дугаар сарын 28-ны өдөр ашиглалтад оруулах гэрээг 2004 онд байгуулжээ. Гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн авсан атал 2005 оны 12 дугаар сарын 19-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

## **В. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох аргачлал, заавар үгүйлэгдэж байна.**

ХХААЯ “2005 онд ХХАА-н салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 225 худаг шинээр гаргаж буюу сэргээн засварлаж 331.5 мянган га бэлчээр буюу 800.0 мянга гаруй толгой мал, 4 мянга орчим хүн амын ундны усны нөхцөл сайжирч ашиглалтгүй байсан бэлчээрийг ашиглах боломжтой болсон, Завхан аймгийн ХХААГ-ын барилга болон уурын зуухны засварын ажлын үр дүнд хөдөө орон нутгийн мэргэжилтнүүдийн ажиллах нөхцөл сайжирсан, нийслэлийн Эмээлт дэх МЭГ-ын барилга Түүхий эдийн төв захын дэргэд баригдснаар арьс шир, түүхий эдэд шинжилгээ хийхэд дөхөм болж малаас хүнд халдварлах өвчнөөс сэргийлэх ач холбогдол бүхий ажил боллоо” гэж 2005 оны хөрөнгө оруулалтын үр дүнг дүгнэжээ.



Гэвч Засгийн Газрын 2005 оны 200 дугаар тогтоолоор отрын бүс нутаг 11 аймагт 23 худаг шинэчлэн засварлах, нэг худаг дунджаар 3.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байхаар тооцсон атал Ховд аймагт 1 худгийг 9 сая төгрөгийн өртгөөр гаргасан байна.

ХХААЯ-нд хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох үзүүлэлт тодорхой бус, гүйцэтгэгч бүрийн хийсэн ажил харилцан адилгүй, тухайлбал худгийн гүн, ундрогын хэмжээ, насос байрлуулах гүн, тээврийн зардал (аймаг сумаас хэр зэрэг алслагдсанаас хамаарч) гэх мэт гол үзүүлэлтүүд худаг бүрд өөр байдгаас төсвийг харьцуулах боломжгүй байна.

ҮХЯ геологийн зураглал хийх төсөлд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгөөс ашиглагдах боломжгүй болсон, гэрээ батлагдахгүй байгаа зэргээс шалтгаалан зарцуулагдаагүй үлдсэн төсвийг хэмнэлтэд тооцсон нь Сангийн сайдын 2005 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 365 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс давсан орлого, хэмнэгдсэн зардлыг зарцуулах, тайлагнах журам”-ын 3.6-д “Хөрөнгө оруулалт, их засварын гүйцэтгэгч бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтын хэмнэлтийг хэмнэгдсэн зардалд тооцохгүй ” гэж заасантай зөрчилдөж байна.

Дээрх байдлаас үзэхэд хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох аргачлал алга байна.

#### **Зөвлөмж:**

##### **Сангийн сайд н. Баяртсайханд**

- Хуурамч баримт бүрдүүлж ажлын гүйцэтгэлийг буруу ташаа тайлагнасан захиалагч, гүйцэтгэгч нарт зохих журмын дагуу хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах,
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг оны эцэст хийж, он дамжсан үлдэгдэл үүсгэдэг практикийг өөрчлөх,
- Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох нэгдсэн аргачлал, заавар боловсруулж мөрдүүлэх,

## Хавсралт

Хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

мянган төгрөгөөр

№	Байгууллага	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга	300000,0	299668,9	331,1
2	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс	100000,0	99000,0	1000,0
3	Төрийн тусгай хамгаалалтын газар	410000,0	409395,5	604,5
4	Стандартчилал хэмжил зүйн төв	50000,0	49673,7	326,3
5	ЗГХЭГ	2400000,0	2395667,5	4332,5
6	ГХАЭС	450000,0	449900,0	100,0
7	ТЭХЯ	15556400,0	15528341,4	28058,6
8	БХБЯ	1047000,0	1016933,9	30066,1
9	ЗТАЖЯ	22094600,0	21911722,8	182877,2
10	БСШУЯ	7871500,0	7844023,4	27476,6
11	ЭМЯ	3448000,0	3443330,4	4669,6
12	СЯ	2597000,0	2302269,2	294730,8
13	ГХЯ	460000,0	459851,0	149,0
14	ХХААЯ	702100,0	675233,5	26866,5
15	НХХЯ	150000,0	95287,7	54712,3
16	ҮХЯ	247000,0	242940,1	4059,9
17	БОЯ	124000,0	123961,8	38,2
18	ХЗДХЯ	1092400,0	1091304,4	1095,6
19	Улсын дээд шүүх	25000,0	24750,0	250,0
20	Шүүхийн ерөнхий зөвлөл	365000,0	264998,0	2,0
21	УМХГ	100000,0	100000,0	0
22	БХЯ	300000,0	300000,0	0
23	Улсын Ерөнхий Прокурор	50000,0	50000,0	0
	Нийт дүн	59960000,0	59298253,2	661746,8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР-Т

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2008.08.29 № 4-94/3657  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал хүргүүлэх тухай

Танай газраас улсын төсвийн 2005 оны хөрөнгө оруулалт, их засварын зардлын гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Орхон аймгийн гэр хорооллын доторхи 3.5 км авто замын ажлын гүйцэтгэл 59.1 сая төгрөгийг өмнө олгосон 120.0 сая төгрөгөөс суутган тооцолгүй санхүүжүүлсэн нь "Авто замын тухай" хуулийн 18.4 дэх заалтыг зөрчиж орон нутгийн авто замын ажилд улсын төсвөөс санхүүжилт олгосон тул 120.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхээр акт тогтоосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2005 оны төлөвлөгөөний төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх үед Орхон аймгийн гэр хорооллын доторхи авто замын ажилд 500.0 сая төгрөг нэмж тусгах талаар УИХ-ын гишүүн Д.Одхүүгийн гаргасан санал Эдийн засгийн байнгын хорооны болон Чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдэж, төсөвт тусгагдсан.

Иймд ажлын гүйцэтгэгч "Булган АЗЗАН" ХК-ийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, 422.6 сая төгрөгийн үнэ бүхий АЗЗ-05-11 тоот гэрээ байгуулсан бөгөөд гэрээний тусгай нөхцлийн 48.0 дахь заалтыг үндэслэн тус компанид 2005 оны 10 сарын 18-нд 120.0 сая төгрөгийн урьдчилгааг Сангийн яамнаас олгосон юм.

Харин түлш, шатах тослох материал, битумын үнийн өсөлтөөс шалтгаалан он дамжин хэрэгжүүлж байгаа зам барилгын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэ өсөх хандлагатай болж, энэ талаар захиалагч ЗТАЖЯ, авто замын компаниудаас удаа дараа ирж байсан хүсэлтийг харгалзан уг ажлын гүйцэтгэл 59.1 сая төгрөгийг оны эцэст санхүүжүүлсэн.

Хэрэв "Авто замын тухай" хуулийн 18.4 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж урьдчилгаа санхүүжилтэд олгосон 120.0 сая төгрөгийг улсын төсөвт актаар буцаан татах тохиолдолд гүйцэтгэлээр олгосон 59.1 сая төгрөгийг ч мөн буцаан татах шаардлагатай болох юм. Нөгөөтэйгүүр уг замын гэрээт ажил бүрэн хийгдэж гүйцэтгэл нь ирэхэд буцаан татсан 120.0 сая төгрөгийг улсын төсвөөс дахин олгоход хүрч байна. Иймд уг 120.0 сая төгрөгийг буцаан татах үндэслэлгүй гэж үзэж байна.

Орон нутгийн авто замыг орон нутгийн замын сангийн хөрөнгөөр засах хөрөнгийн боломж байдаггүйгээс улсын авто замын сангийн хөрөнгийг орон нутгийн авто замын засвар, шинэчлэлтэд өмнөх жилүүдэд зарцуулж байсан, одоо ч ЗТАЖЯ, аймаг, нийслэл, орон нутгийн удирдах байгууллагаас байнга хүсэлт тавьж байдаг бөгөөд "Авто замын тухай" хуульд энэ чиглэлээр өөрчлөлт оруулахыг ЗТАЖЯ-нд зөвлөмж болгуулах саналтай байна.

08 3206

